



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 1/81

Сүхбаатар

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 12.1, 15.12.4, 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын "Энхийн тун" эмийн сан, "Диагнозе" лаборатори, Сүхбаатар сумын "Гэрэл" лаборатори, "Ахмад", "Буянт рашаант 1,2,3,4" эмийн сангууд, Баруунбүрэн сумын Номгон тосгоны эргэлтийн эмийн сангуудын тусгай зөвшөөрөлийг тус тус 1 жилээр сунгасугай.

2. Баруунбүрэн сумын "Зууннаст" эмийн сан, Сүхбаатар сумын "Хар-Од" эмэгтэйчүүдийн эмнэлэг, "Ариун таван хан" ХХК-ий ариутгал халдваргүйтгэлийн байгууллагыг тус тус 1 жилийн хугацаатайгаар тусгай зөвшөөрлийг шинээр олгосугай.

3. Сүхбаатар сумын "Монос-Сэлэнгэ", "Буянтрашаан-1" эмийн сангуудад мансууруулах сэтгэц нөлөөт эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг тус тус 1 жилийн хугацаагаар олгосугай.

4. Комиссын хурлын шийдвэрийг харгалзан хуулийн дагуу хугацаандаа материалаа ирүүлээгүй Сүхбаатар сумын "Анар", эмнэлэг, Сайхан сумын "Дэлгэрэх", Цагааннуур сумын "Тунфарм", Мандал сумын "Азын нахиа" 1,2, "Энх тунх", Зүүнбүрэн сумын "Бүрэн тун" эмийн сан, Зүүнбүрэн, Орхон, Хушаат, Түшиг сумдын эргэлтийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийг тус тус 6 сарын хугацаатайгаар түр сунгасугай.

5. Мандал сумын "Энхийн тун-1" эмийн санг стандартын шаардлага хангаагүй мөн өөрийн хүсэлтээр, мөн сумын "Саян-Уул" эмийн санг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 6 сар үйл ажиллагаа явуулаагүй, Сайхан сумын "Адонис" уламжлалтын эмнэлэг нь хуулийн хугацаанд сунгуулаагүй зэрэг дутагдал илэрсэн тул тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

6. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С. БҮРЭНБАТ

